



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 18 өдөр

Дугаар А/389

Номгон

Иргэн С.Цэцэгмаагийн эзэмшил газрын
зөрчлийг арилгах тухай


Иргэн С.Цэцэгмаагийн (ВЮ67070761) Баянхонгор сум Номгон 1 дүгээр баг, Дэлгэрэхийн-1 гудамж, 101 тоот хаягт байрлах 6409000234 нэгж талбарын дугаартай 630 м2, 64090002341 нэгж талбарын дугаартай 826 м2 талбай бүхий эзэмшил газрууд нь хоорондоо давхцалтай байгаа тул иргэний хүсэлтийг харгалзан Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2, 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэн С.Цэцэгмаагийн (ВЮ67070761) 6409000234, 64090002341 нэгж талбаруудын давхцаж буй талбай болох 144 м2 талбайг 826 м2 эзэмшил газрын урд хэсэгт шилжүүлэн байршуулж залруулсугай.

2.Эзэмшил газрын хэмжээ өөрчлөгдсөнтэй холбогдуулан улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэн ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл), эзэмшил газарт Улсын бүртгэлийн "Э" дугаар олгохыг Улсын бүртгэлийн хэлтэс (Ц.Мөнхжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Эзэмшил газрын 10 хувийг цэцэрлэгжүүлэн зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг иргэн С.Цэцэгмаад үүрэг болгосугай

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

621010979